



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар A/802

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Жаргалант сумын дулааны хуучирч муудсан шугамын засвар"-ын ажлыг гүйцэтгэгч "БГМ" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Ганданповрон

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Г.Тунгалаг

-Ховд хотын захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

М.Нансалмаа

-“Шим Ус” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

Б.Бямбажав

- “Бадамлах дөл” ХХК-ний шугамын мастер

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. "Жаргалант сумын дулааны хуучирч муудсан шугамын засвар"-ын ажлыг гүйцэтгэгч "БГМ" ХХК-ний ажлыг төсөв, ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Жаргалсайхан

Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/802 Ch
02 03914